



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Хуульчдын гудамж 15/1, Бага тойруу,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0027
Утас: 26 08 55, Факс: (976-51) 26 37 39,
Цахим шуудан: gpo@prosecutor.mn,
Цахим хуудас: prosecutor.mn

2025.02.18 № 1/881
танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Х.ТЭМҮҮЖИН ТАНАА**

Таны 2025 оны 01 дүгээр сарын 09-ний
өдрийн УИХ-03/238 дугаартай албан бичгээр
ирүүлсэн Эрүүгийн хууль болон бусад хуулиудад
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй
танилцаад, саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 6 хуудас.

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН
ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ М.ЧИНБАТ



• 15010401371

ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ

Улсын ерөнхий прокурорын газрын
2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн
1./881/дугаартай албан бичгийн
хаасралт

№	Зүйл, хэсэг, заалт	Гаргасан санал				Саналын үндэслэл, хэрэгцээ, шаардлага
		Өөрчлөх	Нэмэх	Хасах		
0	1	2	3	4	5	
Нэг. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл						
1	1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл "Тайлбар: -Энэ зүйлд заасан "хуулийн этгээд" гэдэгт төрийн байгууллага хамаарахгүй.					Иргэний хуулийн 25.1-д "Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ.", 26.1-д "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсэж, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.", 30.2-д "Чиг үүргээ хэрэгжүүлэх болон нийгмийн хэрэгцээг хангах зорилгоор төр өөрийн өмчөөр дангаар буюу хамтран хуулийн этгээд байгуулж болно." гэж заасан. Харин Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-д "хуулийн этгээд" гэж Иргэний

					хуулийн 25.1-д заасан шинжийг агуулсан зохион байгуулалтын нэгдлийг, хэлнэ, 5.1-д “Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн 7.1.8-д заасан улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн этгээдэд “төрийн байгууллага, албан газар” хамаарахаар заасан байна. Иймд “хуулийн этгээд” гэдэг ойлголтод төрийн байгууллагыг хамааруулах эсэхтэй холбоотой хууль тогтоомжийн зохицуулалт өөр өөр байгааг анхаарч үзэх шаардлагатай байна.
2	3 дугаар зүйл. 1/1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Эрүүгийн ял албадлагын арга хэмжээ нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шинж чанар, учруулсан хохирлын хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.	“Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шинж, аюулын хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж өөрчлөх.			Гэмт хэргийг халдлагад өртөж буй объектын шинж, төрлөөр нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн тодорхой бүлгүүдэд тусгаж, хөнгөн, хүнд гэж ангилан, оногдуулах эрүүгийн хариуцлагыг ялгамжтай тогтоосон. Мөн гэмт хэргийн аюулын хэр хэмжээ буюу гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдлыг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тухайлсан гэмт хэргийн үндсэн, хүндрүүлэх болон онц хүндрүүлэх шинжид хамааруулж, ялын төрөл, хэмжээг тогтоохын зэрэгцээ Эрүүгийн хуулийн ерөнхий ангид эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал болгон хуульчилсан. Хуулийн төсөлд гэмт хэргийн шинж, аюулын хэр хэмжээг зөвхөн хохирлын хэр хэмжээгээр хязгаарласан нь Эрүүгийн хуульд заасан дээрх агуулгатай зөрчилдөж байх тул өөрчлөх.
3	3 дугаар зүйл. 2/ 1.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн	“Гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс			Гэм буруугүйгээр хор уршиг учруулах гэсэн хууль зүйн ойлголт нь гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас үүсэх хор

	үйлдэл, эс үйлдэхүйн үр дагаврыг ухамсарлаагүй, хэргийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан, учирч болох хор хохирлыг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсан бол хор уршиг гэм буруугүйгээр учруулсан гэж үзнэ.”	үйлдэхүйн аюулгын шинж, хэр хэмжээг ухамсарлаагүй, хэргийн нөхцөл байдлын улмаас ухамсарлах боломжгүй байсан, учирч болох хор, хохирлыг урьдчилан мэдэх боломжгүй, мэдэх ёсгүй байсан бол хор уршиг гэм буруугүйгээр учруулсан гэж үзнэ.” гэж өөрчлөх.			уршиг, аюулын шинж, хэр хэмжээг ухамсарлаагүй, ухамсарлах боломжгүй байсан нөхцөл байдлыг хэлдэг. Өөрөөр хэлбэл, өөрийн үйлдлийн улмаас бий болох хор уршиг буюу үр дагавраас гадна аюулын шинж, хэр хэмжээг танин мэдээгүй, мэдэх боломжгүй байсан нөхцөл байдлыг илэрхийлнэ.
4	5 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.		Бүхэлд нь хасах	Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд ял, албадлагын арга хэмжээний талаарх ойлголт, түүний төрөл, хэмжээг нарийвчлан, ялгаатай байдлаар тодорхойлсон ба дээрх ойлголтуудыг нэгтгэн, эрүүгийн хариуцлага гэж томъёолсон. Эрүүгийн хуульд албадлагын арга хэмжээг эрүүгийн хариуцлагын нэг төрөл байхаар тодорхойлон хуульчилсан нь бусад хууль болон Зөрчлийн хуульд заасан албадлагын арга хэмжээнээс ялгагдах нөхцөл нь болдог. Хуулийн төслийн танилцуулгад албадлагын арга хэмжээ хэрэглэснийг эрүүгийн хариуцлага	

				хүлээсэнд хамааруулж, хүний эрхийг дордуулж байгаа талаар дурджээ. Гэмт хэрэг үйлдсэн хүнд Эрүүгийн хуульд заасан албадлагын арга хэмжээ хүлээлгэсэн нь гэмт хэрэг үйлдээгүй, гэм буруугүй гэсэн ойлголт болохгүй бөгөөд эрүүгийн хариуцлагын зорилтыг ханган “шударга ёсны зарчим”-д нийцүүлэн ялгамжтайгаар хариуцлага хүлээлгэж буй явдал юм. Үүнтэй холбогдуулан хуулийн төслийн 2 дугаар зүйлд заасан “эрүүгийн хариуцлага” гэснийг “ял, албадлагын арга хэмжээ” гэж өөрчлөх зохицуулалт болон дагалдах 42 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хасах саналтай байна. Түүнчлэн дээрх 42 хуулиас гадна Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хуулиудад “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн зохицуулалт байгаа болохыг дурдах нь зүйтэй байна. Тухайлбал, Автогээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль гэх мэт.
Хоёр. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл				
1 дүгээр зүйл. 10.31.Хөгжлийн банкны тухай хууль зөрчих.				Дагалдах хуулийн төслүүд дотор Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулсан байх бөгөөд Хөгжлийн банкны тухай хуулийн 31.1-31.1.6 дахь заалтыг хүчингүй болгохоор тусгасан нь үндэслэлтэй байна.
5	1.1. Хөгжлийн банкны тухай хуулийн 10.1-т заасныг зөрчсөн албан тушаалтныг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Бүхэлд нь хасах		Харин хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлд “Монгол Улсын

1.2. Хөгжлийн банкны тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан хяналт шалгалтад саад учруулсан бол иргэнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 1.3. төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан буюу гүйлгээг саатуулсан ажилтан, албан тушаалтныг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 1.4. тайлан тэнцэл, мэдээ баримтыг зохих хууль, журмын дагуу гаргаж өгөөгүй буюу Хөгжлийн банкны тухай хуулийн 30 дугаар зүйлд заасны дагуу холбогдох байгууллагад хүргүүлээгүй, нийтэд мэдээлэх санхүүгийн тайланг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй бол албан тушаалтныг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зуун тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 1.5. нийтлүүлсэн тайлан, мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол уг тайлан, мэдээллийг баталгаажуулсан Гүйцэтгэх захирал, эрх бүхий бусад албан тушаалтныг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр,				Хөгжлийн банкны тухай хууль зөрчих” үйлдлийг зөрчилд тооцсон. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлд заасан “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль зөрчих” зөрчилд хамаарах үйлдлүүдийг төслийн 1 дүгээр зүйлд давхардуулсан байна. Тухайлбал: Төслийн 1.1-д заасан “Хөгжлийн банкны тухай хуулийн 10.1 дэх хэсэгт “Хөгжлийн банк дараах шаардлагыг хангасан төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлнэ” гэж заасан ба Зөрчлийн тухай хуульд “Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд заасан төсөл, хөтөлбөрт тавигдах шаардлагыг зөрчсөн” бол гэж заасан; Төслийн 1.2-д заасан “Хөгжлийн банкны тухай хуулийн 27 дугаар зүйлд “Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт”-ын талаар заасан ба Зөрчлийн тухай хуульд “Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд тус банкны хянан шалгалчийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулж байгаа хяналт шалгалтад саад учруулсан; Төслийн 1.3-1.6-д заасан үйлдлүүдийн талаар Зөрчлийн тухай хуулийн 11.17 дугаар зүйлийн 3-т “Төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан, эсхүл гүйлгээг саатуулсан бол...”, 4-т “Тайлан тэнцэл, мэдээ баримтыг зохих хууль, журмын дагуу гаргаж өгөөгүй”, 5-д “Нийтлүүлсэн тайлан, мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол уг тайлан, мэдээллийг
---	--	--	--	---

хуулийн этгээдийг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 1.6. Хөгжлийн банкны тухай хуулийн 8.2-т заасныг зөрчсөн албан тушаалтныг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.				баталгаажуулсан” үйлдлийг зөрчилд тооцсон байна. Иймд хуулийн төслөөс энэ зүйлийг бүхэлд нь хасах нь зүйтэй байна.
--	--	--	--	---

---000---